



МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 11 сарын 16 өдөр

Дугаар А/615

Есөнбулаг

Гэрээ байгуулах эрх олгох тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.3 дахь заалт, 46.3 дахь хэсэг, Үнэлгээний хорооны 2023 оны 11 дүгээр сарын 15-ны өдрийн 66 дугаар зөвлөмжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. "Солонго дулааны станц" аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын хөрөнгөөр санхүүжигдэх ГААОНӨГ/202307063 дугаартай "Солонго дулааны станц" аж ахуйн тооцоот үйлдвэрийн газарт нүүрс нийлүүлэх ажлыг "Тэнүүн Шарга Алтай" ХХК-тай гэрээ байгуулан гүйцэтгүүлэх эрхийг "Солонго дулааны станц" аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар (А.Дэлгэржаргал)-т олгосугай.

2. Ажил гүйцэтгэх хугацаа, ажлын тоо хэмжээ, техникийн тодорхойлолт зэргийг үндэслэн холбогдох хууль, журмын дагуу эрх үүрэг захиалагчийн хяналт, хариуцлагыг гэрээнд тодорхой тусгаж, хэрэгжилтийг тайлагнаж ажиллахыг "Солонго дулааны станц" аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар (А.Дэлгэржаргал)-т үүрэг болгосугай.

3. Ажлын гүйцэтгэл, чанар, санхүүжилтэд хяналт тавьж ажиллахыг Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс (Л.Хаш-Эрдэнэ), Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтэс (Э.Пүрэвжав)-т тус тус даалгасугай.

ОРЛОГЧ



Г.ЧИНБАТ